



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/294

Мөрөн сум

Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "б", 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1, 8.2 дахь заалт, 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.1, 27¹.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/178 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Үерийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, холбогдох сум, байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг зохион байгуулж ажиллуулсугай.

2.Шуурхай штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, гүйцэтгэх ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, баг бүлгийн зохион байгуулалтад шилжүүлж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч М.Хуягбаатарт, Шуурхай штабын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг байгууллага аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

4.Сум орон нутагт үерийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, аймгийн Онцгой комисс, түүний Шуурхай штабыг өдөр тутмын мэдээллээр хангах бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Шуурхай штабт шаардагдах зардлыг тухай бүр шийдвэрлэж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбилгүүнд даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



6712010915



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Орлогч дарга:

Нарийн бичиг:

Гишүүд:

М.Хуягбаатар – Аймгийн Засаг даргын орлогч

С.Ганболд – Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа

А.Баянхангай – Онцгой байдлын газрын гамшгаас

хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах

мэргэжилтэн, ахмад

Б.Оюунтуяа – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн

бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Г.Базар – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн

сангийн хэлтсийн дарга

С.Батхуяг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн

штабын дарга, хурандаа

Б.Өнөрбат – Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга

Д.Мөнхжаргал – Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа

Я.Эрхэмбаяр – Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга

М.Үүрийнбаяр – Эрүүл мэндийн газрын дарга

Л.Ариунаа - Мал эмнэлгийн газрын дарга

Б.Уртнасан-Зоонозын өвчин судлалын төвийн дарга

З.Бадрал – Хөвсгөл эрчим хүч ХХК-ний захирал

Б.Ганзориг – Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын
дарга

Ө.Баттулга – Автотээврийн төвийн дарга

Т.Раднаабүд – Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга

П.Мөнхжаргал – Байгаль, Орчин аялал жуулчлалын газрын дарга

Д.Сүхбат – Хөвсгөл Ус суваг ХХК-ний захирал

Б.Галбадрах – Хөвсгөл АЗЗА ХХК-ний захирал

Г.Чинчулуун – Улаан загалмай хорооны дарга

Х.Тайванбаяр - Мөрөн сумын Засаг дарга

Ц.Зоригт - Мөрөн Хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ний
захирал